

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2020.03.05, №08 (137)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№517

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ЧИЛИЙГ ЧИГЛЭХ ЦАГААР



НИЙТЛЭЛ

Н.Соёлгэрэл
Аюулгүй байдал судлаач

МӨНХИЙН ХӨРШҮҮДИЙН МААНЬ "ЗУЗААРСАН" ХУДАЛДААГ

COVID-19 нилмгэлэх үү?

БНХАУ-д анх дэгдсэн шинэ төрлийн коронавирусын тархалт (2019-nCoV/COVID-19) тэлж, халдвар авагчдын тоо нэмэгдсээр хэдийнээ таван тив, 70 гаруй улсыг хамарчээ. Эм, ерөндгийг гарган авах ажиллагаа олон оронд хийгдэж, үр дүнгийн талаар төрөл бүрийн мэдээллүүд гарч, клиникийн туршилт хийгдэж эхэлсэн ч ерөндгийг гарган авахад жил гаруйн хугацаа шаардагдахыг ДЭМБ-аас албан ёсоор сануулсаар байна.

IV НҮҮРТ

Удалгүй УИХ-ын хаврын чуулганаар МУ-ын "Алсын хараа 2050", урт хугацааны бодлогын баримт бичгийг хэлэлцэх гэж байна. Энэ баримт бичгийн эдийн засгийн хэсэгт уг нь сонирхолтой олон санаа, зорилго оржээ. 30 жилийн хугацаанд эдийн засаг 6 дахин томорч 78 тэрбум ам.доллар, нэг хүнд ногдох ДНБ 4 дахин өсч, 15 мянган ам.доллар болох ажээ. Өнөөгийн Чили, Польш, Хорват зэрэг улсуудын түвшинд очих юм байна.

30 жилийн дараа "манай эдийн засагт бүтцийн эрс өөрчлөлт гарч, боловсруулах аж үйлдвэр болон бусад шинэ салбарууд хөгжиж, эдийн засаг бодитойгоор олон тулгуурт болох нөхцөл бүрдэж байна. Монгол Улсын эдийн засгийн гадаад зах зээлээс хамааралтай эмзэг байдал арилж, хэрэглэгч эдийн засгаас үйлдвэрлэгч эдийн засаг руу шилжиж, дараах үндсэн салбараар эдийн засгийн бүтэц тодорхойлогддог" болох гэнэ.

Зураг 1: Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлснээр гарах үр дүн

Хүснэгт 4.1. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлснээр гарах үр дүнгийн прогноз

Үзүүлэлт / он	2030	2040	2050
ДНБ /2018 оны ханшаар/	32.1 тэрбум ам.доллар	54.0 тэрбум ам.доллар	77.7 тэрбум ам.доллар
1 хүнд ногдох ДНБ	8299 ам.доллар	12004 ам.доллар	14682 ам.доллар
Эдийн засгийн салбарын ДНБ-нд эзлэх хувь:			
Уул уурхай	31.4%	26.8%	25.3%
Боловсруулах аж үйлдвэр	14.6%	20.3%	27.4%
Тээвэр, логистикийн аж ахуй	4.8%	9.7%	11.6%
Бусад	49.2%	43.2%	35.7%




- ▶ Засгийн газрын энэ баримт бичигт улс орон эдийн засагт ямар үр дүн гарах тухай бичсэн болохоос, ямар арга замаар, яаж түүнд хүрэх тухай тодорхой хэлээгүй байна. Эдийн засгийн энэ бүтцийг төр өөрөө бүтээх юм уу, эсвэл хувийн хэвшил үү, хөгжлийн гол хөдөлгүүр болох зах зээлийн зарчмаараа явах юм уу, эсвэл яах тухай тодорхой дурдаагүй байна.

АВААГҮЙ СУРГАМЖ

Монголд эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай тухай бид бараг 20 жил ярьж ирлээ. Эдийн засгийн хагас нь, экспорт нь бараг бүхлээрээ эрдэс, түүхий эдээс хамааралтай орон ямар их бэрхшээл, сорилттой тулгардаг, эдийн засгийн өсөлт, уналт нь улс төр, нийгмийн амьдралд ямар хүчтэй нөлөөлдгийг монголчууд энэ хугацаанд хангалттай ойлгосон ч, сургамж авч чадахгүй л байна.

Зураг 2: Уул уурхай ба бусад салбарын экспортод эзлэх хувь хэмжээ




Эх сурвалж: Эдийн засгийн судалгаа, шинжилгээний хүрээлэн (ERI)

Эдийн засгийн өсөлтийг дагаад экспортын зарим бүтээгдэхүүний хэмжээ өссөн ч, хувийн жин нь нэмэгдэхгүй байна. Эдийн засаг нь манайх шиг бүтэцтэй орнуудыг рентийн¹, Голланд өвчин туссан, баялгийн занганд орсон зэргээр тайлбарладаг. Эдгээр орнуудын зарим нь байгалийн нөөцөө ашиглан дундаж орлоготой болж чадах ч, ихэнх нь эдийн засгаа төрөлжүүлэхээс өөр сонголтгүй болдог. Гэтэл байгалийн баялаг ихтэй орнуудад рентийн төлөө тэмцэл нь улс төр, эдийн засгийн инстүүцүүдээ сулруулж, улмаар баялгийнхаа занганд ордог (Пол Коллер, “Адагт үлдсэн тэрбум”).

Монгол Улсад нийтийн засаглал сул, засгийн эрх баригч улс төрийн намуудын санхүүжилт нууц, төр засаг нь тогтвортой биш учраас авлига буурахгүй, шүүх засаг нь хараат бус болж чадахгүй байна. Тийм учраас Монгол Улсын өрсөлдөх чадвар сул, нүүрс, зэс зэрэг цөөхөн эрдэс, ноолуураас өөр бүтээгдэхүүн дэлхийн зах зээл дээр нийлүүлж, эдийн засгаа төрөлжүүлж чадахгүй байна.

Зураг 3: Экспорт 2019 онд, барааны бүлгээр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2019 онд МУ-ын экспортод эрдсийн бус бүтээгдэхүүн 16 хувийг эзлэж байна. Гол шалтгаан монголын төр засаг гаргасан шийдвэрээ хэрэгжүүлж чадахгүйд байгаа юм. Засгийн газар 1998 онд “Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр” зарлаж, Үндэсний зөвлөл нэртэй агентлаг хүртэл байгуулахаар болсон ч хэрэгжүүлж чадаагүй. Дараа нь 2013 онд “Экспортыг дэмжих хөтөлбөр” гаргасан ч, аль аль нь биелсэнгүй. 2018 оноос “Монгол экспорт” хөтөлбөр гаргаад явж байна.

Өмнөх баталсан бодлого, хөтөлбөрүүд яагаад биелэхгүй байгаа шалтгааныг шинжилж судалдаггүй; угаасаа явц, үр дүнг нь үнэлж дүгнэдэггүй; хяналт, хариуцлага тооцдоггүй; эрх баригчид дандаа ирээдүй цаг дээр ярьсаар ирсэн учир эдийн засгаа солонгоруулах бодлого нь цаасан дээр үлдсээр өдийг хүрсэн. Хамгийн гол нь төрийн нэрээр хувийн бизнес хийх зуршил батжин бэхжиж, улс төрийн клиентелист тогтолцоо бүрдэж, бүр хууль зүйн хамгаалалтанд орсонд л хэргийн учир оршино. Энэ сургамжаа харин монголын төр авахгүй, авч чадахгүй байгаа юм даа.

Төр нь ухаалаг бодлого гаргаж, түүнийгээ тууштай, эрчимтэй хэрэгжүүлэн уул уурхайгаас хараат байдлаа өөрчлөн, олон тулгуурт эдийн засагтай яаж болох тухай бусад орны туршлага юу байна вэ?

ЧИЛИЙН САН

- ▶ Өмнөд Америкт, Атлантын далайн эргийг эмжин орших, 19 сая хүнтэй энэ улс байгалийн баялгаас хамааралтай эдийн засгийн бүтцээ өөрчилж, дэлхийд өрсөлдөх чадвартай экспортын салбарыг бий болгохын төлөө олон жил тууштай ажиллаж иржээ.

Өнөөдөр Чилийн нийт экспортын тал хувийг зэс, үлдсэн хэсгийг самар, жимс, дарс, үхрийн мах, загас, мод модон бүтээгдэхүүн зэрэг эзлэж байна. Эдгээр бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргаж, өрсөлдөх чадвартай болгоход төр хувийн хэвшлийн түншлэл, засгийн газрын байгуулсан хоёр болон олон талт гэрээ хэлэлцээрүүд, экспортыг дэмжих төрийн бодлого, инстүүцүүд чухал үүрэг гүйцэтгэжээ.

Өнөөдөр Чилийн загас, загасан бүтээгдэхүүн гэхэд л дэлхийн хэрэглээний 8 хувийг хангаж байна. 1970-аад онд Чилийн энэ салбарт Америк, Японы компаниуд орж ирсэн ч, олигтой амжилтанд хүрээгүй юм. Тэр компаниудыг төр, хувийн хэвшлийн хамтарсан “*Чилийн Сан*”-ийн санаачилгаар байгуулсан Salmenes Antartica компани худалдан авч Норвегийн туршлагыг судлаж, технологийг нь оруулснаар үйлдвэрлэл эрс нэмэгджээ. Мөн Японы Засгийн газартай хамтран төсөл хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалт татаж чаджээ. Эхлээд Чилийн загасны аж ахуйн салбарт ердөө 4 компани байсан бол 10 жилийн дотор 200 болж, кластер (хонхорцог) үүсгэжээ. Salmenes Antartica компани нь эхний том хөрөнгө оруулалт хийж яргай загасыг нутагшуулж, үржүүлэх технологи, мэдлэг туршлагаа хувийн хэвшилтэй хуваалцаж, тэднийг өрсөлдөх чадвартай болгожээ.

Яг энэ аргаараа дэлхийн түвшний жимсний аж ахуй байгуулжээ. Өмнө нь алим, усан үзэм гэсэн хоёрхон төрлийг гаргадаг байсан бол, өнөөдөр Чили хориод төрлийн жимс гаргаж, Латин Америкийн хамгийн том, жимс экспортлогч болжээ.

Жимс, жимсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн ахиц

дэвшлийг дагаад зөвхөн дотоодын хэрэгцээгээ анхаарч ирсэн дарсны салбарт ч амжилт гарлаа. Бизнес тэлж, гадны компаниуд орж ирэхдээ шинэ технологи, хөрөнгө оруулалт авчиржээ. Өнөөдөр Чили дэлхийн дарсны зах зээлийн 4 дэх том экспортлогч болоод байна.

Энэ амжилтын цаана нь төр хувийн хэвшлийн хамтын “Чили Сан”-аар дамжуулан төрөлжүүлэх салбарынхаа судалгааг (R&D) эхнээс нь сайн хийж, бизнес төлөвлөгөөний тууштай хэрэгжүүлэлт байгаа юм. Эхлээд тулгарсан хамгийн том асуудал бол ур чадвартай, боловсон хүчин хүрэлцэхгүйд байлаа. Иймээс Калифорнид 80 гаруй оюутныг хөдөө аж ахуйн чиглэлээр сургажээ. Энэ хөтөлбөрийг нь АНУ-ын “Фордын сан” санхүүжүүлж, өнөөгийн ханшаар бол 200 орчим сая ам.долларыг зарцуулжээ. Ер нь төрөлжүүлэх салбартаа боловсон хүчин бэлдэх хөтөлбөрөө боловсруулахдаа АНУ-тай хамтран ажиллаж, Форд, Рокфеллер зэрэг хувийн хэвшлийн буяны сангууд дэмжиж Чилийн их сургууль, судалгааны хүрээлэнгүүдэд шаардлагатай техник, хүний нөөцийн хөрөнгө оруулалтыг хийжээ.

Гадаадын хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд Чилийн их сургууль, хүрээлэнгүүд дэмжиж, судалгаа хөгжүүлэлт хийж, чанарын удирдлага, хяналт хийхэд нь оролцож иржээ. Харин гадагшаа гаргахад нь экспорт хариуцсан төрийн агентлаг (*ProChile*) нь хувийн хэвшилдээ тусгайлан дэмжлэг, туслалцаа үзүүлдэг. Тухайлбал Чили дарсыг олон улсад таниулах маркетингийн зардлын талыг нь энэ агентлаг санхүүжүүлж байлаа. Импортыг орлуулж, өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүн бий болгох зорилготой ProChile, Corfo зэрэг байгууллагууд Чилийн амжилтанд ихээхэн үүрэгтэй оролцжээ. Чилийн эдийн засаг ийнхүү төрөлжин хөгжиж, шинэ салбарууд нь бойжин томорч, энэ улс эдүгээ дэлхийн зах зээл дээрх том тоглогч болсон.

30 ЖИЛИЙН АЛСАД

30 жилийн дараа Монгол хүний амьдрал дөрөв дахин дээшилсэн байх эсэх нь төр засаг аль хэр тунгалаг, авлига багатай байхаас л хамаарна. Бусад бүх хүчин зүйл манайд хангалттай байна. Эдийн засгаа төрөлжүүлэх салбараа зөв сонгох; төр хувийн хэвшил хамтарсан судалгаа хийж, стратеги боловсруулах; шаардлагатай хөрөнгө оруулалт босгох; боловсон хүчнээ гадаад, дотоодод бэлтгэх зэрэг ажил биднийг хүлээж байна. Анхдагч компани нь төр, хувийн компаниуд хамтарсан байх, харин туршлага мэдлэгээ хувийн хэвшилд түгээсний дараа хувьцаат компани болгох замаар явж болно.

Мөн одоо байгаа төрийн өмчит бүх компанийг хувьцаат компани болгож, хөрөнгийн зах зээл дээр

гаргах, төрийн оролцоог 35 хувиас хэтрүүлэхгүй байх, компани томрохын хэмжээгээр арав арван хувиар нь хувьцаагаа борлуулж, орлогоор нь тухайн салбарын цаашдын хөгжлийн судалгаанд зарцуулах хөтөлбөр гаргах шаардлагатай байна. Төр зохицуулагч, шүүгч болохоос тоглогч байхаас аль болох татгалзах хэрэгтэй. Үнийг чөлөөлж, зах зээлд оролцогчдод шударга өрсөлдөх, урт хугацаандаа зөв төлөвлөх боломж өгөх цаг ирчихсэн шүү дээ.

Энэ бүхнийг хийхгүй бол Алсын хараа 2050 маань зэрэглээ шиг алсраад байхаас, ойртохгүй.

2020.03.05

1 Рент нь эдийн засагт бодит зардлаас давсан хэт өндөр ашиг олохыг хэлдэг бөгөөд энэ бол байгалийн баялагтай орнуудын нийтлэг зовлон. Энгийн үгээр хэлвэл зовлон багатайгаар өндөр ашиг олохыг рент гэж болно. Төрийн янз бүрийн лиценз, зохицуулалтаас үүсдэг Рент (rent-seeking) гэх үзэгдэл. Төрийн эрх мэдлээ ашиглаж зовлон багатайгаар бизнес хийх сонирхолтой бүлгийг “rent-seekers” гэнэ.



НИЙТЛЭЛ


Н.СОЁЛГЭРЭЛ

Аюулгүй байдал судлаач

ТӨНХИЙН ХӨРШҮҮДИЙН ТААНЬ “ЗУЗААРСАН” ХУДАЛДААГ *Covid-19 нимгэлэх үү?*

БНХАУ-д анх дэгдсэн шинэ төрлийн коронавирусын тархалт (2019-nCoV/COVID-19) тэлж, халдвар авагчдын тоо нэмэгдсээр хэдийнээ таван тив, 70 гаруй улсыг хамарчээ. Эм, ерөндгийг гарган авах ажиллагаа олон оронд хийгдэж, үр дүнгийн талаар төрөл бүрийн мэдээллүүд гарч, клиникийн туршилт хийгдэж эхэлсэн ч ерөндгийг гарган авахад жил гаруйн хугацаа шаардагдахыг ДЭМБ-аас албан ёсоор сануулсаар байна.

Зураг 1. COVID-19-ийн тархалтаас дэлхийн болон Хятадын эдийн засагт учирч буй сорилтууд¹



COVID-19 ийнхүү хурдтай тархаж байгаа нь дэлхийн эдийн засагт ноцтой хохирол учруулахаар байгаа юм. Халдвар тархахаас сэргийлэхийн тулд олон улсын авч хэрэгжүүлж буй гол арга хэмжээ болох хорио цээрийн дэглэмийн үед иргэд, тээврийн хөдөлгөөнийг хязгаарласнаас дэлхийн эдийн засаг, ялангуяа хоорондын худалдаа, хөрөнгийн зах зээлд томоохон эрсдэл үүсээд байна. Эдгээрээс хоёр хөршөө онцлон, сүүлийн жилүүдэд зузаараад байсан эдийн засгийн харилцаа нь хэр нимгэрч, ямар хохирол амсаж буйг энэ удаад тоймлохыг зорив. Талуудын харилцаан дахь бүхий л салбарт сорилт учирч байгаагаас эдийн засгийн салбарт нь хамгийн их эрсдэл учрахыг шинжээчид онцолж байна.


ОРОС-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААН ДАХЬ ҮР ДАГАВАР

Орос, Хятадын худалдаан дахь дараах хэдэн салбарыг түшиглэн, нөхцөл байдлыг тодорхойлохыг хичээе.


А. НЕФТЬ БА ХИЙ

Хятадын Цагаан сар эдийн засгийнх нь бүхий л салбарт ямар нэг байдлаар нөлөөлдөг. Энэ жилийн тухайд аялал жуулчлал, жижиглэн худалдаа, автомашин, электроник, үйлдвэрлэл, агаарын болон төмөр замын тээвэр зэрэг салбарт сөрөг нөлөө дагууллаа. Хятадын дотоодод зорчих иргэдийн тоо 2019 оны мөн үетэй харьцуулахад энэ жил 55% -аар буурчээ. Энэ бол ганцхан баримт. Энэ мэт хүчин зүйлсийн улмаас Хятадын эдийн засгийн өсөлт 2020 онд 1 хүртэлх хувиар буурах урьдчилсан тооцоог гаргаад байна. БНХАУ-ын ДНБ-ий өсөлт 2019 оны 6.2%-аас 2020 оны эцсээр 5.5%-д хүрч буурах² таамаг байгаа аж. Цаашлаад дэлхийн худалдааны 12% ноогддог Хятадад учирч буй хүндрэлийн улмаас дэлхийн эдийн засгийн өсөлт мөн буурч болзошгүй байна.

Хятад бол Оросын хамгийн том худалдааны түнш бөгөөд, Оросын эдийн засаг Хятадынхаас нэлээд хамааралтай гэж хэлж болно. ОХУ-аас 2018 онд Хятадад нийлүүлсэн экспортын бүтцийн дийлэнх нь эрчим хүчний түүхий эдийн нөөцийн бүтээгдэхүүнүүд (эрдэс түлш, газрын тос, тосон бүтээгдэхүүн) байжээ. Гэтэл одоо Хятадын газрын тосны эрэлт өдөрт 2 сая баррелиар буураад байна. Үүнтэй давхцан мөн дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурч байна. Хоёрдугаар сарын 27-ны байдлаар WTI маркын газрын тосны дөрөвдүгээр сарын фьючерс 1.54%-аар буурч, баррель нь 47.98 доллар болсон бол дөрөвдүгээр сард нийлүүлэх Brent маркын нефтийн үнэ 1.48 хувиар буурч, баррель нь 52.64 доллар болжээ³. Харин яг хоёрдугаар сарын сүүлийн долоо хоногт ханш бараг 15 орчим хувиар унасан үзүүлэлт бүртгэгджээ. Энэ мэт үйл явдал өрнөсөн өнгөрсөн сарын сүүлийн 7 хоногийг АНУ дахь томоохон хувьцааны индексүүд хүртэл 2008 оны санхүүгийн хямралаас хойшхи хамгийн муу үзүүлэлт үзүүлсэн долоо хоног болсныг онцолж байна.




Зураг 2. Хятадын ДНБ-ий өсөлтийн төлөв



Эх сурвалж: BBVA Research and CEIC

Дэлхийн эрчим хүчний зах зээлд Хятад улс томоохон тоглогч. Тиймдээ ч 2019 онд дэлхийн газрын тосны эрэлтийн өсөлтийн 75 хувь нь Хятадад ноогдож байлаа. Оны өмнө тус улс газрын тосны 2020 оны хэрэглээгээ өдөрт 600 мянган баррель болгон нэмэгдүүлж, энэ нь дэлхийн газрын тосны эрэлтийн өсөлтийн гуравны нэг байх болно гэж таамаглаж байсан бол вирусын тархалтын улмаас энэ дүн огцом унаж, эхний улиралд гэхэд л газрын тосны эрэлтийн өсөлтийн дөнгөж 20%-тай тэнцэж, өдрийн хэрэглээ нь 435 мянган баррель байхаар шинээр тооцжээ. Дэлхийн зах зээл дээр хүртэл газрын тосны эрэлтийн хэмжээ энэ оны нэгдүгээр улирлын эцсээр 1,3 сая хүртэл баррелиар буурах төлөв гаргажээ⁴.



Эх сурвалж: Breakthrough

Байгалийн хийн зах зээлд мөн сөрөг үзэгдэл ажиглагдаж байна. Хятадын шингэрүүлсэн байгалийн хий импортлогчид төлөвлөсөн худалдан авалтынхаа 70%-ийг цуцлаж магадгүй байна. Хятадад 2018 онд

дэлхийн байгалийн хийн худалдан авалтын 17% ноогдож, 2017–2018 оны дэлхийн эрэлтийн өсөлтийн 55%-ийг дангаар эзлэж байсан. Хятадын хийн хэрэглээний 40% нь үйлдвэр, ААН-үүдэд ноогддог⁵ тул хорио үргэлжилж, эдгээрийн үйл ажиллагаа нь зогсонги байдалд байсаар байвал дотоод дахь хэрэглээ нь огцом буурахад хүрнэ. Энэ мэт эрчим хүчний зах зээл дэх сөрөг үзэгдэл хэсэгтээ хадгалагдсаар байхыг мэргэжилтнүүд онцолж байна.

Мэдээж Хятадын эрчим хүчний түүхий эдийн дотоодын эрэлт буурвал хоёр талын худалдааны өсөлтийн хөдөлгөгч хүч болох Орос-Хятадын эрчим хүчний хамтын ажиллагаанд хүндрэл учрах нь дамжиггүй. Өнгөрснийг эргэн санавал, 2018 онд ОХУ-аас Хятад руу нийлүүлсэн эрчим хүчний түүхий эдийн экспортын өсөлт 55.1% болж, экспортын нийт бүтцэд эзлэх хувь нь өмнөх онд 66.2% байсан бол мөн онд 71.6% болж өссөн⁶ байна.

Дашрамд дурдахад 2019 оны эцсээр талууд жилдээ 38 тэрбум куб.метр хүртэл хэмжээний хий дамжуулах хүчин чадалтай “Сибирийн хүч” дамжуулах хоолойг нээсэн. Мөн 2017 оны 11-р сард Хятадын Үндэсний Газрын тосны корпораци нь (CNPC) ОХУ-аас Дачин руу газрын тос дамжуулах шугамын хоёр дахь хэсгийг газрын тосны экспортыг хоёр дахин нэмэгдүүлж, жилд 30 сая тоннд хүргэх зорилготойгоор барьж дуусгасан. Улмаар 2019 онд Орос улс Хятадын газрын тосны нийт импортын 16%-ийг (77.64 сая тонн)⁷ дангаар хангаж, Саудын Арабын дараа Хятадын хоёр дахь том газрын тос нийлүүлэгч болсон юм.

Зураг 5. Хятадын газрын тосны импорт /экспортлогч улсуудаар/



Харин одоогийн нөхцөл болох Хятадын дотоод дахь эрчим хүчний түүхий эдийн эрэлт багасч, дэлхийн зах зээл дээрх үнэ буурч байгаа энэ үед Орос, Хятад хоёуланд нь хоорондын худалдааны эргэлтийн өсөлтийн өнөөг хүртэлх хурдаа цаашид хадгалж үлдэхэд нь бэрхшээл тулгараад байна. Дашрамд дурдахад, мөн Хятадын тухайд АНУ-тай байгуулсан Худалдааны гэрээний эхний үе шатыг хэрэгжүүлэх хүрээнд АНУ-аас Хятадад

эрчим хүч нийлүүлэх тухай тохиролцоо биелэхэд мөн хүндрэл учирч байна. Тохиролцоо ёсоор Бээжингийн зүгээс ОХУ, Венесуэл, Саудын Арабаас худалдан авах газрын тос, байгалийн хийн худалдан авалтын тодорхой хэсгийг АНУ-д хэсэгчлэн шилжүүлэх, нийлүүлэлтийн зах зээлээ төрөлжүүлэх үүрэг хүлээсэн. Тэгэхээр одоо бүх зүйл Бээжингийн шийдвэр, тэдний сонгох стратегийн шугамаас хамаарна. Тэдний АНУ-тай байгуулсан гэрээндээ их ач холбогдол өгөх үү, эсвэл уламжлалт түншүүд болох Орос, Венесуэлтэй эрчим хүчний хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэхийг илүүд үзэх эсэхийг цаг хугацаа харуулах нь ээ.

Б. ХӨДӨӨ АЖ АХҮЙ


Коронавирусын сөрөг нөлөөнд өртөж болзошгүй талуудын хамтын ажиллагааны өөр нэг чиглэл бол хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдаа. Хэдийгээр энэ нь хоорондын худалдааны өсөлтийн гол хүчин зүйл биш (2018 онд ОХУ-ын Хятадад нийлүүлсэн ХАА-н бүтээгдэхүүний экспортын хэмжээ хоорондын нийт худалдааны 5.4%, Хятадаас ОХУ руу гаргасан экспорт 4.1%-ийг л эзлэж байжээ) хэдий ч өсч буй салбар бөгөөд, ялангуяа Кремлийн зүгээс ихээхэн ач холбогдол өгч, дэмжиж байгаа юм. Үр дүнд нь ОХУ-аас Хятадад нийлүүлсэн ХАА-н бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2017 онтой харьцуулахад 2018 онд 51,4%-аар өссөн аж.

Хоёр талын ХАА-н чиглэлийн худалдаанд ОХУ-д Хятадаас нийлүүлж буй бүтээгдэхүүнтэй холбоотой ариун цэврийн болон фитосанитарийн стандартыг мөрдөхтэй холбогдсон асуудал ихээхэн сорилт болж байна. Хятадтай энэ чиглэлээр худалдаа хийж байгаа улсуудын адил дүрэм журмыг Оросын зүгээс мөрдөх гэхээр Хятадын худалдаанд хүндхэн тусах нь ойлгомжтой. ХАА-н бүтээгдэхүүн Хятадаас импортолдог Зүүн Өмнөд Азийн орнууд Хятадаас ирж буй бүх хөлөг онгоцонд 14 хоногийн хорио цээрийн дэглэмийг нэвтрүүлсэн нь хадгалалтын богино хугацаатай бүтээгдэхүүн муудахад хүрч, улмаар үйлдвэрлэгчид, ханган нийлүүлэгчдийн хүлээх алдагдлыг нэмэгдүүлжээ. Малайз улс гэхэд л Хятадаас гахайн мах, түүнтэй холбоотой бүтээгдэхүүн импортлохыг бүрэн хориглосон. Ариун цэврийн хяналтыг чангатгахгүй ч тээврийн урсгалыг хязгаарлах нь ч мөн ялгаагүй (ялангуяа агаарын тээвэр) худалдааны эрчмийг бууруулж, бүтээгдэхүүнийг муудахад хүргэх хүчин зүйл болно. Үүссэн нөхцөл байдлын улмаас Оросын зарим жижиглэн худалдааны сүлжээнүүд хэдийнээ Хятадаас ХАА-н гаралтай бүтээгдэхүүн (жимс, хүнсний ногоо) худалдан авахаас татгалзаж, бараа татан авалтаа Турк, Марокко зэрэг бусад зах зээл рүү чиглүүлэхээр

оролдож байгаа аж. Жишээлбэл, Хятадад цагаан сарын амралт залгаад хорио цээрийн хугацаа сунгагдаж байгаатай холбогдуулан боловсруулах үйлдвэрүүд ажиллахгүйн улмаас Оросын наймаалжны махны эрэлт Хятадад 2020 оны эхний улиралд 7-8 мянган тонн болж буурч, улмаар орлого нь тэн хагасаас илүү хувиар буюу 60-70 сая ам. доллараар буурч магадгүй байна.

V. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Вирусын улмаас хил гааль, тээврийн урсгалын хорио тавигдсаны сөрөг үр дагаврыг мэдрэх өөр нэг салбар бол аялал жуулчлал. Судалгаанаас үзэхэд 2019 онд Хятадын Орос руу жуулчилсан иргэдийн тоо бусад улсын жуулчдын тооноос давжээ. Хятадын 1.5 сая жуулчны тоо 2018 оны тооноос 19% -аар их байна. Хятад эх сурвалжуудад ч Хятадаас ОХУ руу аялагчдын урсгал их байгааг батлаж байгаа юм.



Өмнөд хөршийн эх сурвалжид дурдсанаар, 2018 онд Хятадын жуулчдыг ихээр татаж чадсанаараа Орос нь БНСУ, Япон, АНУ-ын дараа жагссан байна. Одоо харин хорионы улмаас Оросын аялал жуулчлаын салбар 100 орчим сая ам.долларыг алдахад хүрээд байна. Яг энэ тоо их биш байж болох ч Хятадаас ирэх жуулчдын урсгал сэргэхэд удаан хугацаа шаардагдах тул цаашдаа илүү их хэмжээний алдагдал ч хүлээж магадгүй гэж Оросын шинжээчид тооцоолж байна. Хятад руу чиглэх Оросын жуулчдын урсгалаас ч мөн Хятадын эдийн засаг тодорхой хэмжээний хохирол амсах нь. Хятадын хэвлэлүүдийн мэдээлснээр, Оросын эдийн засгийн байдал аажмаар сайжирч байгаагаас тус улсаас ирэх жуулчдын урсгал 2019 онд огцом нэмэгдсэн аж.

Хорионы хугацаа удаан үргэлжилсэн тохиолдолд талуудын эдийн засгийн хамтын ажиллагааны эрч суларсаар байхыг хоёул зөвшөөрч байна. Тиймээс

Кремлийн өмнө Хятад руу нийлүүлэх Оросын экспортыг төрөлжүүлэх асуудал тулгарч, шийдлээ хүлээж байх шиг. Бас нэг асуудал бол Оросын үйлдвэрүүдийн Хятадын түүхий эдээс хамааралтай байгаа явдал юм. Гэхдээ ганц ОХУ ч биш, дэлхийн олон улс, тэдгээрийн үйлдвэрлэгчид Хятадын ханган нийлүүлэгчдээс хамааралтай байгаа. Хятадад үйлдвэрүүд түр зогсож, хаагдсанаас болж бусад улсын электроник, автомашин, хувцас үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчид ажлаа бүхэлд нь зогсоох юм уу, шинэ нийлүүлэгч хайх, өөр альтернатив хувилбарын эрэлд гараад байна. Ялангуяа Оросын хувцас, электроник, автомашин үйлдвэрлэгчид Хятадаас шаардлагатай материалыг авчрахгүйгээр ажиллах боломжгүйг эдийн засагчид нь сануулж байна. Ниссаны Санкт-Петербург дахь үйлдвэр гэхэд л Хятадаас цаг тухайд нь түүхий эд, хэрэгслээ аваагүй тохиолдолд үйлдвэрлэл тасалдахад хүрээд байгааг анхааруулаа.

Эцэст нь цөөн үгээр дүгнэхэд, мэдээж хэрэг Хятадад дэгдэж, дэлхийн олон улсыг хамраад буй шинэ төрлийн коронавирусын улмаас дэлхийн эдийн засаг, болон хоёр талын худалдаанд учрах эрсдлийг тооцож, эдийн засгийн алдагдлын хэмжээг бодитоор үнэлэх цаг одоо хараахан болоогүй байна. Зөвхөн мөсөн уулын орой төдий зүйл л харагдаж байна. Бидний мөнхийн хөршүүдийн тухайд хоорондын худалдаа, экспортын бүтцэд нь төрөлжүүлэлт хангалтгүй байгаа энэ тохиолдолд ялангуяа Оросын эдийн засгийн төлөвлөлтөд сорилт учирч болзошгүй юм. Гэхдээ бас эрсдлийг боломж болгох жишгээр улс төрийн найрсаг харилцаа, бусад өргөн нөөц бололцоондоо түшиглэн шинэ арга замуудыг эрэлхийлэх бүрэн боломж тэдэнд буй нь эргэлзээгүй.

2020.03.04

- 1 "Coronavirus could trim 1 percentage point from China GDP growth: government researcher", <https://www.reuters.com/article/us-china-economy-health/coronavirus-could-trim-1-percentage-point-from-china-gdp-growth-government-researcher-idUSKBN20506X>
- 2 "The impact of COVID-19 outbreak on China's External Balance", <https://www.fxstreet.com/analysis/the-impact-of-covid-19-outbreak-on-chinas-external-balance-202002261440>
- 3 "Oil prices are falling", <https://news.am/eng/news/562610.html>
- 4 "Price Impacts of the Coronavirus on Global Fuel Markets", <https://www.breakthroughfuel.com/blog/coronavirus-global-fuel-markets/>
- 5 "Coronavirus could hit China's 2020 natural gas demand", <https://www.spglobal.com/platts/en/market-insights/latest-news/natural-gas/020520-coronavirus-could-hit-chinas-2020-natural-gas-demand>
- 6 "Запуск «Силы Сибири» поможет «Газпрому» снизить зависимость от Европы", <https://www.vedomosti.ru/business/articles/2019/12/02/817690-zapusk-sibiri>
- 7 "China's 2019 oil imports from Saudi Arabia rise 47 percent", <https://www.brecorder.com/2020/02/04/567643/chinas-2019-oil-imports-from-saudi-arabia-rise-47-percent/>